

Булган аймаг дахь төрийн
аудитын газар
үйл ажиллагааны
тайлан



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2020

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2020.12.15.

Булган

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Үндэсний аудитын газраас 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын стандартын шинэчлэлийн жил” болгон зарлаж дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж эхний хагас жилийн ажлын тайланг МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/235 тоот тушаалаар баталсан журмын дагуу тайлагнаж байна.

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 онд нийт 11 орон тоотойгоос жирэмсэн, амаржсаны чөлөөтэй байсан 2 аудитор 05 дугаар сарын 01, 11-ний өдөр тус тус ажилдаа орсон, түр орлон гүйцэтгэгчээр МУЕА-ын Б/170 тоот тушаалаар томилогдсон А.Анхбаяр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул өргөдлийг 02 дугаар сарын 18-ны өдрийн 56 тоот албан бичгээр МУЕА-ын орлогчид хүргүүлж шийдвэрлүүлсэн, ҮАГ-ын 2017 оны 1906 тоот албан бичгийн дагуу нягтлан бодогчоор 1 хүн түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулж байгаа, одоогоор орон тоо бүрэн ажиллаж байна.

Шинэ коронавирус /Covid19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн тайлангийн ид ачаалалтай үеэр аудитор, харилцагч байгууллагуудын ажилтнуудыг улс, аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа горим, дэгийг сайтар сахиулж аливаа зөрчил, дутагдалгүй ажиллаж, байгууллагаас хээрийн 2 постонд өглөө, өдөр, оройн хоолоор үйлчилсэн, ажилтнууд 03 дугаар сарын 02, 13-ны өдөр 2 удаа 4 цагийн хуваарьт олон нийтийн эргүүлд гарсан, 03 дугаар сарын 15-ны өдөр аудитын менежер аймгийн Шуурхай штаб дээр 14 цагаар ажилласан, Монгол улсад “Covid-19” өвчлөл дотооддоо бүртгэгдсэн, улсын хэмжээнд зарлаад байсан гамшгаас хамгаалах хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг ахиулж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3-ыг үндэслэн Засгийн газраас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг зарласантай холбоотойгоор авах арга хэмжээний тухай МУЕА-ын А/83 тоот тушаалыг хэрэгжүүлэхээр “Covid-19 –ийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г 11 дүгээр сарын 12-ний өдөр гаргасан, мөн нөхцөл байдалтай холбогдуулан 19-ний өдөр шинэчлэн гаргаж хэрэгжүүлсэн, 3 ажилтан аймгийн хариуцлагатай жижүүрээр 14 цагийн турш ажилласан.

“Covid-19” өвчлөлтэй холбоотой ҮАГ-ын удирдлагаас цахим хурлаар өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж аудиторуудын ажлыг 2 цагаар богиносгон харилцагч талуудтай цахимаар харилцах, 0-12 настай хүүхэдтэй эцэг, эхэд цалинтай чөлөө олгох, гэрээсээ ажлаа хийх боломжоор хангахад гэр интернетийн төлбөрийн хөнгөлөлтөнд 275.0, ариутгалын бодисонд 92.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, хамт олны зүгээс аймгийн Онцгой комиссоод 200.0 мянган төгрөг, 50 ш амны хаалт хандивласан.

Тайлант хугацаанд батлагдсан орон тоогоор нийт 2445 хүн/өдөр ажилласнаас 38.65 хувь буюу 945 хүн/өдрийг санхүүгийн тайлангийн аудитад, 14.81 хувь буюу 362 хүн/өдрийг гүйцэтгэлийн аудитад, 17.1 хувь буюу 418 хүн/өдрийг нийцлийн аудитад, 29.45 хувь буюу 307 хүн/өдрийг удирдлага зохион байгуулалт, дотоод ажил, сургалт, зөвлөгөөн, бичиг хэрэг, үйлчилгээ, бусад ажилд тус тус зарцуулсан байна.

Газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг УБ хотын “Грант тронтон аудит” ХХК-иар баталгаажуулж зөрчилгүй дүгнэлт авсан, аудитаар өгсөн зөвлөмжийн хариуг 06 дугаар сарын 02-ны өдрийн 185 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Тэргүүлэх аудиторын ХАСХОМ-ын баталгааны маягтыг гаргаж Хүний нөөцийн албанд хүргүүлж, ажилтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хянаж баталгаажуулсан, Төрийн албаны хүний нөөцийн цахим системд ажилтнуудын мэдээллийн шинэчлэлт хийсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу МУ-ын Ерөнхий аудиторын орлогчоор гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан Тэргүүлэх аудиторын 2020 оны А/02 тоот тушаалаар санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хуваарийг батлан мөрдөж ажилласан.

Ажлын ачаалал, хүн хүчний нөөц, цаг хугацааны байдлаас шалтгаалан нийт аудиторууд СТА, ГА, НА-ыг хийдэг байсныг энэ оноос эхлэн 3 баг болгон дагнасан байдлаар аудитуудыг гүйцэтгэснээр аудитын чанар, үр нөлөөнд ахиц гарсан, ажлын үүрэг хариуцлага ч дээшилсэн үр дүн гарлаа.


Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитад жил бүр гаднаас 2 гэрээт ажилтан авч ажиллуулахад аудитын чанар, үр өгөөжид муугаар нөлөөлж байсныг харгалзан өөрийн гэрээт нягтлан бодогчтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулан аудитын стандарт, журмыг судлуулан заавар, зөвлөмж өгч ажиллуулснаар аудитын үр дүн, чанарт ахиц өөрчлөлт гарсан чухал ажил болсон.

Газрын болон аудиторуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр журмын дагуу биелэлтийг тооцож аудиторуудын ажлыг дүгнэж ажиллалаа.

Тайлант хугацаанд удирдлагын зөвлөлийн хурлыг 3, ажилтнуудын хурлыг 6 удаа хийж 9 асуудал хэлэлцэж 9 шийдвэр гаргаж, үүрэг даалгаврыг тухай бүр өгч ажиллалаа.

СУГ-ын 2020 оны 04/3125 тоот албан бичгийн дагуу Төрийн аудитын байгууллагын 2021 онд хийх гүйцэтгэлийн төлөвлөгөөний зардал, хугацаа, зорилт, хүрэх түвшинг тодорхойлсон 47 ажлыг тусгаж 09 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар санал хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-д 2021 оны аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 3 тооны **831.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг 3 тооны **270.0** сая төгрөгөөр бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх 5 тооны саналыг боловсруулан хүргүүлсэн.



Акт, албан шаардлага: ҮАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн ИТХ-ын захиалга, аймаг дахь Төрийн аудитын газрын өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитаар 2020 онд шинээр нийт 146 актаар 121.8, 124 зөрчилд 3108,4 сая төгрөгийн албан шаардлага өгч төлбөрийн актын 99.31 хувь буюу 145 актын 121.2 сая төгрөгийг барагдуулж, албан шаардлагын 84.99 хувь буюу 115 тооны 2641.7 сая төгрөгийг хэрэгжүүлж үлдсэн акт, албан шаардлагууд хугацаа болоогүй байна.

Өмнөх оны 22 тооны актын үлдэгдэл 378.9 сая төгрөгөөс 21 тооны 377.8 сая төгрөгийг барагдуулсан, үлдэгдэл 1 тооны 1.1 сая төгрөгийн акт нь барагдаагүй тухайн сумууд хууль, шүүхийн байгууллагад өгөхөөр үлдээд


байгаа сум хөгжүүлэх сантай холбоотой, 1 тооны 37.7 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдлийг бүрэн барагдуулж ажиллалаа.

Өмнөх болон энэ оны төлбөрийн актын биелэлтээр санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн төсөвт 66.1, тухайн байгууллагад 74.0, бусад хэлбэрээр 227.0, гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн төсөвт 9.4, тухайн байгууллагад 13.0, бусад хэлбэрээр 4.3, нийцлийн аудитаар орон нутгийн төсөвт 27.5, тухайн байгууллагад 0.2, бусад хэлбэрээр 75.4 **нийт дүнгээр орон нутгийн төсөвт 103.0, тухайн байгууллага болон тусгай санд 87.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн, бусад хэлбэрээр 356.7 сая төгрөгийг барагдууллаа.**

Алдаа зөрчил: Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар 630 тооны 5590.1, гүйцэтгэлийн аудитаар 72 тооны 1168.4, нийцлийн аудитаар 64 тооны 2506.2 нийт 766 тооны 9264.7 сая төгрөг алдаа зөрчил илрүүлж ажиллалаа.

Нийт алдаа зөрчлийн 0.02 хувь буюу 185.6 сая төгрөг нь орон нутгийн орлого бүрдүүлэлттэй, 38.16 хувь буюу 3535.2 сая төгрөг нь НББ-ийн тайлагналтай, 3.18 хувь буюу 294.3 сая төгрөг нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 41.59 хувь буюу 3853.4 сая төгрөг нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 9.99 хувь буюу 925.2 сая төгрөг нь дотоод хяналт, хариуцлагатай, 4.04 хувь буюу 373.9 сая төгрөг нь худалдан авалттай, 1.0 хувь буюу 92.6 сая төгрөг нь зориулалт бус зарцуулалттай, 4.6 хувь буюу 0.05 сая төгрөг нь бусад асуудалтай холбоотой байна.

Илэрсэн алдаа, зөрчлийн 60.34 хувь нь санхүүгийн тайлангийн аудитаар, 12.61 хувь нь гүйцэтгэлийн аудитаар, 27.05 хувь нь нийцлийн аудитаар илэрчээ.



Аудитын зөвлөмжөөр 2020 онд шинээр бүртгэгдсэн 405 тооны 2480.9 сая төгрөгийн 346 буюу 85.43 хувийг санхүүгийн тайлангийн аудит, 41 буюу 10.12 хувийг гүйцэтгэлийн аудит, 18 буюу 4.45 хувийг нийцлийн аудит эзэлж нийт зөвлөмжийн 341 буюу 84.2 хувийг хэрэгжүүлж, үлдэх 64 буюу 15.8 хувь нь хэрэгжих шатандаа хугацаа болоогүй 10, 11 дүгээр сард хийгдсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын зөвлөмжүүд байна.

Өмнөх оны хугацаа болоогүй байсан 33 тооны 560.3 сая төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Үр өгөөж:

Төрийн аудитын байгууллагуудын хэмжээнд дэвшүүлсэн нийтлэг зорилт аймаг, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, төрийн өмчит аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган илэрсэн алдаа зөрчлийг залруулах, ажил сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг тооцож хангуулах, телбер, зерчлийг барагдуулах, төрийн байгууллагын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө нөөц боломжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж, хариуцлагын механизмыг сайжруулах, аймгийн ИТХ, Засаг даргад хийсэн аудитын дүнг танилцуулах, бодитой үнэн зөв мэдээллээр хангах зэрэгт аудитын байгууллага үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласнаар үйл ажиллагааны үр дүнгийн статистик үндсэн гол үзүүлэлтүүдэд зарим ахиц өсөлт гарсан дүнтэй байна.

Тайланг хугацаанд нийт 606 тооны 4904.6 сая төгрөгийн санхүүгийн, 20 тооны санхүүгийн бус үр өгөөж тооцлоо.

Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, татгалзсан дүгнэлт авсан, зөрчил гаргасан 32 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргад албан бичиг хүрүүлснээр 13 албан тушаалтанд хариуцлага тооцсон, 19 албан тушаалтанд хуулийн өөрчлөлттэй холбоотой хариуцлага тооцох боломжгүй болсон байна.

Хууль хяналтын байгууллагад 1 тооны 1.7 сая төгрөгийн асуудлыг шилжүүлж бүрэн шийдвэрлэсэн.

ХОЁР.Санхүүгийн аудитын талаар:

МУ-ын Ерөнхий аудиторовн тушаалаар баталсан санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийх хуваарийн дагуу МУ-ын Ерөнхий аудиторовн 2018 оны А/124 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, 2019 оны А/60 тоот тушаал, ЯАГ-ын 2019 оны А/87 тоот ерөнхий чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай албан бичиг, САГ-аас ирүүлсэн төсвийн шууд захирагчдын аудитын тайлангийн загвар, анхаарах зүйлс зэргийг баримтлан СТАУС программад оруулан аудитыг амжилттай хийлээ.

Тэргүүлэх аудиторын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/32 тоот тушаалаар аудит хийх аудитор, байгууллагын хуваарийг баталж, аудит эхлэхийн өмнө сум, байгууллагын удирдлагад ажлын нөхцөл, хүн хүч, цаг хугацааны хязгаарлагдмал байдал, аудит хийх хуваарь зэргийг дурьдсан 2020 оны 03 тоот албан бичгийг хүргүүлж ажилласан.

Санхүүгийн тайланг баталгаажуулахдаа тайланд тусгагдсан тоо, аудитын тооцооллыг түргэн шуурхай, үнэн зөв гаргах, санхүүгийн тайлангийн үзүүлэлт, уялдаа холбооны алдааг илрүүлэх, санхүүгийн тайлан баталгаажуулахад хэрэглэж хэвшсэн өөрсдийн боловсруулсан 17 дахь жилдээ хэрэглэж байгаа бичил программд оруулан шалгаж алдааг шалгасны дараа СТАУС программд мэдээлэл оруулан дахин шалгах замаар аудитыг хийлээ.

Аудитаар Төрийн аудитын газар 200, гэрээгээр хараат бус аудитаар 22 нийт 222 байгууллагаас 117 байгууллагад дүгнэлт гаргах, 98 байгууллагыг түүвэрт хамруулах, 7 байгууллагад итгэл үзүүлэхээр төлөвлөсөн, аудитад Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбарыг түүвэрт хамруулахаар нэмэгдэж 223 байгууллагыг аудитад хамруулахаас 7 байгууллагад итгэл үзүүлэн, 96 байгууллагыг түүвэрт хамруулж, хуулийн хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүйгээс 5 байгууллага аудитад хамрагдаагүй, 115 байгууллагад дүгнэлт гаргаснаас зөрчилгүй 96, “Хязгаарлалттай” 18, “татгалзсан” 1 санал дүгнэлт өгсөн.

Шүүхийн шийдвэрээр ажлаас буруу халагдсан гэж буцааж ажилдаа томилогдсон Нийгмийн даатгалын хэлтсийн 5, Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 1 ажилтны цалинг төсвөөс олгосон 40.8 сая төгрөгтэй холбоотой албан шаардлагын хууль зүйн үндэслэлийг УАГ-ын хуулийн зөвлөхөөр хянуулж НДЕГ-т 04 дүгээр сарын 03-ны өдрийн 153 тоот албан бичгээр хүргүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу холбогдох хавсралт маягт, загваруудаар ажлын баримт материалыг иж бүрэн бүрдүүлэхэд анхаарч аудиторчуудын ажлын ачаалал, цаг, хүн хүчний нөөц боломжийг бүрэн дайчлан ажилласнаар нийт аудитад хамрагдсан 223 байгууллагаас 201 буюу 90.00 хувийг өөрсдийн хүчээр хийж, “Далай ван аудит” ХХК-ий Орхон аймаг дахь салбартай гэрээ байгуулан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, эрүүл мэндийн салбарын 22 байгууллага буюу 10 хувийг гүйцэтгүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 110 тооны 74.1 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 89 тооны 1466.1 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс актын 109 тооны 73.5, албан шаардлагын 83 тооны 1103.6 сая төгрөгийг барагдуулсан, 6 тооны 363.0 сая төгрөгийн албан шаардлага бүрэн барагдаагүй, аудитаар илэрсэн зөрчил, дутагдал, ажил сайжруулах, хөрөнгийг үр нөлөөтэй зарцуулах, санхүүгийн тайланг хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэх, удирдлагыг мэдээллээр хангах, ажил сайжруулах талаар аудитын дүгнэлт гаргасан байгууллагын дарга, эрхлэгч нарт 346 тооны 1158.6 сая төгрөгийн хугацаатай зөвлөмжийг хүргүүлж 8 тооны 212.7 сая төгрөгийн зөвлөмж дутуу хэрэгжилттэй байна.

Өмнөх оны нийт 14 тооны 295.7 сая төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулсан.

Нийт 533 тооны 1966.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, нийт ажилласан хүн өдрийн 38.65 хувь буюу 945 хүн/өдөр, 71.3 сая төгрөгийг

санхүүгийн тайлангийн аудитад зарцуулсан, хуанлийн хоногоос нийт аудиторууд 182 хүн өдөр буюу 1456 цаг илүү ажилласан тооцоо гарлаа.

Санхүүгийн аудитын талаарх МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн хэмжээгээр сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, зарим сумын ЗДТГ-ын дарга, орлогч дарга нарт урамшууллыг давхардуулан олгосон, шүлхий өвчний үеэр цалинтай ажилласан хүмүүст цалин, нэг удаагийн урамшууллаас мөнгө олгосон, цэцэрлэгүүдийн худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг таслан зогсоож ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг хийсэн.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолоор аймгийн 2019 оны төсвийн орлогыг 61026.9 сая төгрөгөөр баталсан боловч Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3¹-т зааснаар Сангийн яамнаас зарцуулах зөвшөөрөл олгосны дагуу урьд оны үлдэгдлийг 4224.1 сая төгрөгөөр буюу 1209.2 сая төгрөгийг нэмэгдүүлэн үүнээс улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 35091.7 сая, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоор 22872.6, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 3062.5 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 4224.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, орон нутгийн орлогоос 21977.1 сая төгрөгийг оруулж, орон нутгийн орлогын төлөвлөгөө 287.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитаар аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.6-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр гаргаж, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллаагүй, орон нутгийн төсвийн орлого үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого тасарснаас шалтгаалж 287.4 сая төгрөгөөр тасалсан, гадаад албан томилолтын зардалд олгосон 32.9 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд хичээл үйлдвэрлэлийн зардалд төлөвлөн, тайлагнасан, аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй зэрэг зөрчил илэрч ТЕЗ-д төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг бодитой төлөвлөж, үндэслэлийг сайжруулах, гадаад албан томилолтын зардлыг төлөвлөж зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллыг зөв тайлагнах, өмнөх оны орлогын дутууд дүн шинжилгээ хийж ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлтэд дотоод аудит хийж, үр дүнг тооцож ажиллах зэрэг 7 зөвлөмж өгч хэрэгжүүлж ажиллалаа.

ГУРАВ. Гүйцэтгэлийн аудитын талаар:

Нэгдсэн удирдамжаар хийсэн гүйцэтгэлийн аудитын талаар:

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд, үр ашиг”, “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-т хийх аудитыг тогтоосон хугацаанд хийсэн.

¹ Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд, үр ашиг”

Аудитаар нийт 932.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын явцад 4.3 сая төгрөгийн төлбөрийн зөрчлийг барагдуулж 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 923.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

УТХО-аар хэрэгжсэн “Шинэ хөдөө” төслийн төсөл арга хэмжээний ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй комиссын гишүүд, барилга байгууламжийн ажлын явц гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гаргаагүй, санхүүжилтийг бүрэн олгохоор анхан шатны баримт бүрдүүлсэн, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон холбогдох ажилтнуудад арга хэмжээ авах санал хүргүүлсэн.

Аудитаар

- УТХО-аар хэрэгжүүлсэн 5 төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалын дүгнэлт гаргаж баталгаажуулаагүй, зураг төсөвгүй 4 төсөл арга хэмжээ батлуулсан,
- Барилга байгууламжийн ажил эхэлснээс хойш газрын зөвшөөрлийг олгож, 4 барилга байгууламжийн газрын зөвшөөрөл олгох тухай захирамж гаргаагүй,
- Төсөл арга хэмжээний 26.6 хувийг намар буюу хүйтний улирал эхлэх үед эхлүүлсэн, зураг төсөв нь хугацаандаа баталгаажиж ирдэггүй, хүлээгддэг, баримт бичгийн бүрдэл дутуу зэрэг шалтгаанаас нь тухайн ажлууд удаашралтай, хугацаандаа ашиглалтад орохгүй эрсдэл үүссэн,
- Зарим нэг барилга байгууламжийн санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаас ОНХС-гаас 2020 онд 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Гүйцэтгэгч компаниуд ажлыг гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгээгүй, хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй, алданги тооцсон боловч ОНТО-ын дансанд төвлөрүүлээгүй, зарим нэг тоног төхөөрөмжийг холбогдох суманд нийлүүлээгүй, эзэмшигч ашиглагчтай гэрээ байгуулж ажиллаагүй, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон,
- 2 барилга байгууламжийг ашиглагч байгууллагууд бүртгэл тайланд тусгаагүй, 2 барилгын ажлын гүйцэтгэл дутуу, дулааны улиралд хийж дуусгахаар албан даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан, барилга байгууламжийн баримт бичгийг архивд өгөөгүй,
- 2019 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлууд нь төлөвлөж тооцсон хүрэх түвшин, үр дүнгээ өгсөн боловч зарим төсөл арга хэмжээний ажлуудад тавих дотоод хяналт сул, үр дүн бага байна гэж дүгнэсэн.

Аудитаар аймгийн Засаг дарга, ХОХБТХ, СТСХ-т 4, ГХБХБГ-т 2, ОНӨГ-т 1 зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж хэрэгжилтийн тоцож ажилласан.

“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн аудитаар

- ЕБС-иудын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, норм норматив хэрэгцээ шаардлагыг хангасан, харилцан уялдаатай байгаа ч зарим нэг хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж байгаа,
- Эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, саналд тулгуурлан шинэчлэн баталж байгаа ч сургалтын хичээлийн хөтөлбөрийг

- жил бүр шинэчилж байгаа нь сурлагын чанарын үзүүлэлтэд нөлөөлж үр дүн багатай хэрэгжсэн,
- Сургалтын хичээлийн хөтөлбөрийг тогтвортой барих бодлого хэрэгжүүлэх шаардлага үүсэж байгаа,
 - Эзэмшвэл зохих боловсрол, ур чадвар, сургалтыг батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч лаборатори сургуулийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөр ижил явагдаж байгаа,
 - Сургуулийн захирал, менежерүүд холбогдох шалгуурт нийцэж байгаа ч мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэврийн насны, мөн мэргэжил тохирохгүй багш нарыг ажиллуулсан,
 - Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин, материаллаг орчин дутмаг,
 - Багш нарын цаг ашиглалт, ирцийн бүртгэл, хөтлөлт хангалтгүй, багш нарын хувийн хэргийн бүрдэлт дутуу, баяжилт хийгддэггүй, багш нарын цагийг сургууль бүр өөр цагийн бүртгэлээр хөтөлсөн, орлон заасан багшийн бүртгэл хөтөлдөггүй,
 - Кабинетуудыг зохих түвшинд тохижуулан сургалтыг хөтөлбөрийн дагуу хичээллэж байгаа боловч БСШУС-дын 2018 оны А/762 тоот тушаалаар баталсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
 - Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг статистик мэдээний прогнозоор авч бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан боловч сүүлийн жилд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны олголт норматив зардлаасаа илүү зарцуулсан,
 - Гадаадын зээл, тусламжаар нийт 344.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу зарцуулсан гэх боловч Азийн хөгжлийн банкны санхүүжилтээс хэрэгжсэн тэтгэлэгт хөтөлбөр 104.0 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй,
 - Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр багш нараас авсан шалгалтын үнэлгээ хувь буурсан,
 - Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг 16 сум 1 тосгоны хэмжээнд дотоод хяналтын баг томилж ажиллуулж байгаа боловч зарим сумын сургуулиудад хийгдсэн дотоод хяналт үр дүн муу,
 - Мэргэжлийн байгууллагуулын зүгээс жилд сургуулиудад түүвэрлэлтийн аргаар хяналт шалгалтыг хийж заавар зөвлөгөө, албан шаардлага хүргүүлж ажилладаг ч хэрэгжилт бүрэн биелэгддэггүй,
 - ЕБС-иудын хичээл практикийн бичиг хэргийн, тоног төхөөрөмжийн зардлуудыг хүртээмжтэй баталж өгддөггүйгээс сургалтын орчин нөхцөл стандартын дагуу анги тохижилт хангагдахгүй, сургуулийн гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох, гарах шат хийгддэггүй,
 - Багш нарын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах орон байрны хангалт байхгүйгээс багшийн хүрэлцээ дутмаг, багш дутагдаж байгаа,
 - ЕБС-иудад аймаг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажил хийгддэггүй, нь боловсролын байгууллага руу чиглэсэн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт хангалтгүй, цогцоор нь шийдэх бодлого төлөвлөх шаардлага үүссэн байна гэж дүгнэсэн.

Аудитаар нийт 4.8 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, дотоод ажил сайжруулахаар 104.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлж хэрэгжүүлж ажилласан.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 13 тооны 13.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 6 тооны 1027.4 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс актыг бүрэн барагдуулсан, 4 тооны 923.4 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, үлдэгдэл албан шаардлага хугацаа болоогүй, аудитаар илэрсэн зөрчил, дутагдал, ажил сайжруулах, хөрөнгийг үр нөлөөтэй зарцуулах чиглэлээр 18 тооны 3.7 сая төгрөгийн зөвлөмж өгч 10 тооны 3.7 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн 6 тооны зөвлөмж хэрэгжих хугацаа болоогүй байна.

Өмнөх оны үлдэгдэл 3 тооны 6.7 сая төгрөгийн акт, 1 тооны 37.7 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн барагдсан.

Аудитад нийт ажилласан хүн өдрийн 14.81 хувь буюу 362 хүн/өдөр, **22.6** сая төгрөгийг гүйцэтгэлийн аудитад зарцуулжээ.

ДӨРӨВ.Нийцлийн аудитын талаар:

2.3.Нэгдсэн удирдамжаар хийсэн нийцлийн аудитын талаар:

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”ийн аудитыг хийж удирдамжаар тогтоосон хугацаанд хийсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Аймгийн хэмжээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 223 байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс Улсын төсвийн 34, орон нутгийн 189 байгууллагаас 18 улсын төсвийн байгууллагыг маягтын дагуу нэгтгэж орон нутгийн 78 байгууллагыг түүвэрт хамруулсан, тайлант онд дээрх түүвэрт хамруулсан байгууллагууд 6.1.1-6.1.6 дахь заалтад хамрагдах 852 мэдээллийг мэдээлэхээс 796 буюу 93.4 хувийг хугацаанд нь мэдээлж, 12 хувийг хугацаа хоцроон мэдээлж 6.6 хувийг огт мэдээлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хуулийн хэрэгжилтийг хэлэлцэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоол баталсан, хуулийн хугацаанд мэдээллээ хоцроосон ажилтнуудад хариуцлага тооцох албан бичиг явуулсан, Сангийн яам, аймгийн Засаг дарга, Санхүү хяналт, аудитын албатай хамтран төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан, аймаг, сумдын ИТХ -аас үүрэг болгосны дагуу төсвийн шууд захирагчдын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажлын тайланг аймгийн ИТХ-д ирүүлж хэвшсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт 72 байгууллагад 13 албан шаардлага, 62 зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах түүвэрт хамруулсан 78 байгууллагын шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаандаа мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийн хэрэгжилт 96.3 хувьтай гүйцэтгэсэн, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах түүвэрт хамруулсан 78 байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийн 3.4 хувийг мэдээлээгүй, хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгаагүйгээс байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбартаа дутуу байршуулсан, хуулийн 5.7 дахь заалтад нэмэлтээр мэдээллийн самбарт ил тод мэдээлэх талаар хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгах, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байгаа, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр,

ажил үйлчилгээ гүйцэтгэж буй Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдсан байдал хангалтгүй, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээлэл, төсвөөс авсан санхүүжилтийн дүнг цахим хуудсанд бүрэн байршуулаагүй, хуулийн хэрэгжилтэд аймаг сумдын ИТХ жилд 2 удаа, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар улирал бүр хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч хуулийн 6.9 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэсэн.

Аудитаар аймгийн Засаг даргад Шилэн дансны хуулийн 3.1.1-д заасан байгууллагуудын хугацаандаа мэдээлээгүй мэдээллийг нөхөн байршуулах ажлыг зохион байгуулах, /судалгааны маягт, зөрчлийн нэгтгэл/, шилэн дансны тухай хуулийн 10.1- дэх заалтын дагуу хариуцлага тооцох, хуулийн 5.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх шат дараатай арга хэмжээг авах, хуулийн 3.1.4, 3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагуудыг шилэн дансанд цахим хуудас нээгээгүй, мэдээллээ байршуулаагүй тохиолдолд санхүүжилтийн мэдээллийг бүрэн оруулахад чиглэсэн тусгай заалтыг гэрээнд зааж, хэрэгжилтийг хянах зэрэг 3 зөвлөмж өгч хэрэгжүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон, нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь МУ-ын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухай сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухай намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг хянаж баталгаажуулсан.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”, аргачлалын дагуу зардлын дээд хэмжээг тогтоосон.

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт":

Орон нутгийн хөгжлийн сангаар хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж эхэлснээс хойш олон нийт, багийн иргэдээс санал авах ажил жигдэрсэн, сумдад бүлгийн зохион байгуулалтаар ажлын байр бий болсон, олон нийт ч үүнд ач холбогдол өгдөг болсон, зарим газар цахимаар санал авч байгаа, сум, орон нутаг, байгууллага, олон нийтийн эзэмшлийн газрын тохижилт, засвар үйлчилгээ, тухайн жилд болон цаашид ач холбогдолтой арга хэмжээнд хөрөнгө зарцуулж үр дүн гарсан сайн талууд байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн

- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төлөвлөж батлахдаа иргэдээс санал аваагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй сангийн зорилгод нийцээгүй төсөл, хөтөлбөрийг ИТХ баталдаг зөрчил давтагдсан,
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын” 8 дугаар зүйлийн 8.2, 8.7

дахь заалтыг тус тус зөрчин 130.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн,

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон зардал, төсөл арга хэмжээнд санхүүжилт олгосон,
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтаас 3 сум нийт 86.4 сая төгрөгийн өмчийг бүртгэлд тусгаагүй,
- Сангийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийгээгүй,
- Сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжил, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлага хангах зардалд төлөвлөн зарцуулж байгаа зэрэг зөрчил илэрсэн тул хөрөнгийн зарцуулалт, үр дүнд тавих хяналт сул байна гэж дүгнэж зөрчил арилгуулах, дахин давтан гаргахгүй байх, төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргад 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр илэрсэн нийт 818.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 92.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 724.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, үр дүнг мэдээлэх зөвлөмжийг хүргүүллээ.

Нийцлийн аудитаар нийт 3 тооны 1.5 сая төгрөгийн акт, 22 тооны 92.8 сая төгрөгийн албан шаардлага, 6 тооны 724.3 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс акт, албан шаардлага бүрэн барагдсан, 3 тооны 724.3 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжих хугацаа болоогүй байна.

Өмнөх оны нийт 5 тооны 76.5 сая төгрөгийн төлбөрийн актаас 4 тооны 75.4 сая төгрөгийг барагдуулсан, аудитад нийт ажилласан хүн/өдрийн 17.10 хувь буюу 418 хүн/өдөр, 26.4 сая төгрөгийг нийцлийн аудитад зарцуулжээ.

ТАВ.ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар:

Аймгийн ИТХ-ын захиалгаар хийх аудитаар “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”, **өөрийн санаачлагаар** “Аймгийн төсөв, сангийн 2019 оны хөрөнгө оруулалтын үр дүн”, ЖДҮДС-д **гүйцэтгэлийн**, “Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”, “Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн” зэрэг 2 **нийцлийн** аудит хийсэн.

Аймгийн төсөв, сангийн 2019 оны хөрөнгө оруулалтын үр дүн:

Аймагт 2019 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1404.9 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолоор батлуулсан, тус тогтоолын 2-р хавсралтаар аймгийн ОНХО-аар 38 төсөл, арга хэмжээг 1213.5, 3-р хавсралтаар авто замын сангийн хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээг 312.0 сая төгрөгөөр тус тус хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, хийсэн ажлын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулж олгосон, хийгдсэн ажлууд нь удаашраагүй, гэрээний дагуу цаг хугацаандаа хийгдсэн байна.

2019 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар автомашин, засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн тендер зарлагдаж хууль журмын дагуу хийж гүйцэтгэсэн боловч Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга шинээр

барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4-т “Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг <хамгийн сайн> тендер гэж үзнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул тендерт оролцогчид Сангийн яаманд гомдол гаргаж шаардлага хангасан хамгийн бага үнийн санал болгосон компанийг дахин үнэлгээний хороогоор сонгон шалгаруулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар сумын ЗДТГ-ын суудлын авто машиныг шинэчлэхэд суманд 50.0 сая төгрөгийн эрх шилжүүлэхэд Хангал сум тоног төхөөрөмж худалдан авах данснаас 10.0, Орхон сумын ЗДТГ-ын суудлын авто машиныг шинэчлэх ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас 10.0 сая төгрөгийг нэмж 60.0 сая төгрөгөөр суудлын авто машин худалдан авсан, 2019 онд барилга, барилгын их засвар, хатуу хучилттай авто зам, зэрэг ажлыг мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж хийсэн нь Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, тавих хяналтыг бүрэн хийсэж ажилласан байна гэж дүгнэлээ.

Аудитаар аймгийн Засаг дарга, ХОХБТХ, СТСХ-т 2, ОНӨГ-т 1 зөвлөмж өгч ажиллалаа.

“Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”

Дулаан, ус хангамжийн “Булган мээж” ОНӨХХК-д хийсэн аудитаар

- “Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд 4143.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллахаар нийт зардлыг 4439.9 сая төгрөгөөр төлөвлөж нийт ашгийг 38.8 сая төгрөгөөр төлөвлөн батлуулснаас 40.0 сая төгрөгийн орлого илүү бүрдүүлж ажилласан ч 653.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 11 хувьтай хэрэгжсэн,
- Сүүлийн 2 буюу 2017-2018 онд үүссэн дулааны 21.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- Цалин, томилолтын 4134.7 мянган төгрөгийн урьдчилгааг материалаар болон бусад тэтгэмж томилолтын зардлаас суутган тооцсон,
- Тушаал шийдвэргүйгээр 857.5 мянган төгрөгийг түлээ, үр дүнгийн урамшуулалд олгосон,
- ТУЗ болон аудитын хорооны гишүүд нь үйл ажиллагааны тайланг баримтжуулан ажиллаагүйгээс хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны тайланг тайлагнаж ажиллаагүй,
- Мөн ТУЗ-ын дарга, гишүүдэд урамшуулал олгохдоо ажлын үзүүлэлтийг тооцоогүй, тооцсон тухай тайлан дүгнэлт байхгүй, жилд 7.2 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг хийж байгаа боловч цаг хугацаанд нь шимтгэлийг тооцож шилжүүлээгүйгээс 8.9 сая төгрөгийн төлбөрийн актыг төлсөн,
- Дээрх зөрчлүүдээс үзэхэд байгууллагын төлөвлөгөөт хяналт шалгалт болон бусад хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, дотоод хяналт суларсан байна гэж дүгнэсэн.

Аудитаар нийт 46236.6 мянган төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснээс аудитын явцад 857.6 мянган төгрөгийн актын төлбөрийг барагдуулж, 1467.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 29329.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 14581.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлэн хэрэгжүүлж ажиллалаа.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь жилийн санхүүгийн төлөвлөгөөг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж 2267.4 мянган төгрөгийн ашигтай ажиллана гэж тооцоолсноос 4689.6 мянган төгрөгөөр илүү цэвэр ашигтай ажилласан, жилийн үйл ажиллагааны тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж хангалтай гэж дүгнэсэн ч

- Орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн 5 ажлаас 4 ажил нь бүрэн хийгдэж төлөвлөсөн орлогын 94 хувийг бүрдүүлсэн,
- Ажилчидтай хагас бүтэн жилээр тооцоо нийлээгүйгээс 3470.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагын тайланд тусгаж тайлагнаагүй, олон жил босон авлагыг барагдуулаагүй,
- Анхан шатны баримтын бүрдэлт дутуу, е-баримт болон зарлагын баримт зөрүүтэй хавсаргасан,
- Томилолтын зардлыг удирдамж, хөтөлбөргүй зарцуулсан, мөн очсон газраар тамга, тэмдэг, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй,
- Дотоод хяналтыг сумын ИТХ болон Санхүүгийн албанаас хийсэн боловч баримтжуулж ажиллаагүй амаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан зэрэг зөрчлийг арилгуулах 5 зөвлөмж өгч хэрэгжүүлж ажилласан.

Аудитаар нийт 47052.1 мянган төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснээс 3470.0 мянган төгрөгт төлбөрийн акт, 26219.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17362.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-т хийсэн аудитаар

- “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөг 7368.5 мянган төгрөгийн алдагдалтай тооцоолж батлуулсан, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан,
- ТУЗ-ийн дарга байгууллагын бүтэц орон тоог батлахдаа тогтоолын хавсралтад өөрийгөө сар бүр 950.0 мянган төгрөгөөр цалинжуулж ажиллана гээд орон тоонд оруулж баталсан,
- Байгууллагын дарга ажилчдад нөхөн олговор олгох тухай тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж 1200.3 мянган төгрөгийн нөхөн олговрын цалин авсан,
- ТУЗ-ын дарга нь 5843.0 мянган төгрөгийн цалин авсан нь ТӨОХЭТӨТ-ийг хэрэгжүүлэх журмын 3.7²дахь заалтыг үндэслэж цалин авч байгаа боловч тус заалтад санхүү, эдийн засгийн байдал ашиг орлогын үзүүлэлтийг харгалзан үзэж цалин урамшууллыг авч болно гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- Авлага, өглөгийг нэмэгдүүлж ажилласан, авлагыг дутуу тайлагнасан,
- Гэрээ хийгээгүй газраас нүүрсний таталт хийж, хувь хүний данс руу шилжүүлсэн, ХХОАТ суутган тооцоогүй, нэхэмжлэх баримт дутуу бүрдүүлсэн,
- Бэлэн мөнгө их хэмжээгээр гаргасан, кассын тайлангийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан,
- Жилийн эцсээр өглөгийг 6084.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 110115.7 мянган төгрөгийн өглөгтэй, 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь сумын ИТХ болон Засаг дарга, ТУЗ-ын дарга, захирал, гишүүд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй

² Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

үр дүн бага, дотоод хяналт сул гэж дүгнэж 5 тооны зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан.

Аудитаар нийт 30725.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 604.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 21618.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 8502.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж тус тус хүргүүлэн ажиллалаа.

Жижиг дунд үйлдвэрийн санд аудит хийхэд хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьсан тайлан мэдээ байхгүй, үр дүнтэй хэрэгжиж байгаа, хэдэн ажлын байр шинээр бий болгосон нь тодорхойгүй, ХХААГ-ын ЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтний шаардлага хангахгүй тайлан мэдээг нөхөж авсан боловч зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн төслийн хэрэгжилтэд “ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын дагуу хяналт тавиагүй, ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгжээс үйл ажиллагааны тайлан мэдээг хууль журмын дагуу аваагүй зэрэг зөрчил илэрсэн аймгийн Засаг даргад 2 тооны зөвлөмж өгч ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 6 тооны 6.3 сая төгрөгийн акт, 5 тооны 77.0 сая төгрөгийн албан шаардлага, 23 тооны 40.3 сая төгрөгийн зөвлөмж өгч акт, албан шаардлагыг бүрэн барагдуулсан, 2 тооны зөвлөмж хугацаа болоогүй байна.

Өмнөх оны үлдэгдэл акт, албан шаардлага байхгүй, 5 тооны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

“Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”, “Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн”-д хийж байгаа нийцлийн аудит бүрэн дууссан.

“Байгаль хамгаалах сан”гийн 2019 оны үйл ажиллагаа үр дүнд” хийсэн аудитаар

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зарим сумын байгаль хамгаалагчид төсөвт тухай бүр төвлөрүүлээгүй,
- Аймгийн хувьд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын нийт дүнг баримталж байгаа боловч ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах зардлын дүнг хуульчилсан хувь хэмжээнээс дутуу, бусад байгалийн нөөцийг нөхөн сэргээх зардалд илүү хуваарилан зарцуулж байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1³ дэх заалттай бүрэн нийцээгүй,
- Сумын Засаг дарга, ИТХ байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулах төсвийг батлахгүй, орон нутгийн урсгал зардалд зарцуулж холбогдох хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Сумын Засаг дарга нар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлж БОАЖГ-т ирүүлдэггүй,
- Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний 9.5 хувийг зураг, төсөв, эдийн засгийн тооцоололгүйгээр, 4.9 хувийг зориулалт бусаар төлөвлөж, зарцуулсан,

³ .Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

- Ойг нөхөн сэргээх ойжуулалтын ажил үр дүнгүй,
- Тэшиг, Сайхан, Сэлэнгэ сум, Хялганат тосгон байгаль хамгаалах сангийн хөрөнгийг анхан шатны баримтгүй, зориулалт бусаар зарцуулсан,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтаас түүвэрлэн үзэхэд зарим хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгээгүй зэрэг зөрчил илэрсэнд арилгуулах, засаж сайжруулахаар аймгийн Засаг даргад 5 тооны зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар сумдад анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бус зарцуулсан зөрчилд хариуцлага тооцуулах, 3.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 2.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

“Ойн тухай хуулийн хэрэгжилт”-ийн аудитаар 2018-2019 онуудыг хамрах нийцлийн аудитыг нийт төлбөрийн акт 4.6, албан шаардлага 33.8, түлшний модыг талбай тусгаарлалтын гэрээнд заасан үнийн дүнгээр олгоогүй зөрчилд хариуцлага тооцох 6.4 сая төгрөгийн зөрчлийг тус тус оногдуулж холбогдох албан тушаалтанд зөвлөмжийг хүргүүлж дүнгийн хурлаар зөрчлийг танилцуулж ажилласан.

Аудитаар

- ✓ Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, БОАЖГ нь хуульд зааснаар аймаг, сумын түвшинд ойн менежментийн төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар батлуулаагүй, үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ойн менежментийн төлөвлөгөөг батлаагүй, 2019 оны ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх аймгийн галын төлөвлөгөөг боловсруулаагүй, ойн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг тооцоогүй зэрэг ажлуудыг огт хэрэгжүүлээгүй,
- ✓ Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар БОАЖГ, Сум дундын ойн ангиуд нь ойн тухай хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- ✓ Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагааны дээд хэмжээг тогтоосон аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, мод бэлтгэх эрхийн бичиг, хууль тогтоомжоор төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлогын гүйцэтгэлд БОАЖГ, сумдын ЗДТГ -ын хяналт сул,
- ✓ Ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө давж биелж байгаа нь ИТХ-аар баталсан модны дээд хязгаарыг баримталдаггүй, мод бэлтгэх дээд хязгаараас хэтрүүлэн олгодогтой холбоотой,
- ✓ Сумдын түвшинд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ойг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхгүй байгаа,
- ✓ МХГын Улсын байцаагч, БОУБ ойгоос хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэж байгаа боловч үр дүнгээ өгөхгүй, жил бүр орон нутгийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул,
- ✓ Үнэт цаасны бүртгэл тооцоонд тавих хяналт сул байгаагаас модны эрхийн бичиг дутагдуулж, ойн нөөцийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчилд 7 тооны зөвлөмж өгч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Байгаль хамгаалах сан, ойн тухай хуулийн хэрэгжилтийн дүнг аймгийн СТСХ, БОАЖГ, аудитад хамрагдсан сум, Ойн ангийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж санал солилцож ажиллалаа.

Нийцлийн аудитаар нийт 14 тооны 26.2 сая төгрөгийн акт, 2 тооны 444.9 сая төгрөгийн албан шаардлага, 12 тооны 554.0 ая төгрөгийн зөвлөмж өгч актыг бүрэн барагдуулсан 1 тооны 444.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 1 тооны албан шаардлага, 12 тооны 554.0 сая төгрөгийн зөвлөмж хугацаа болоогүй байна.

Өмнөх оны 1 тооны албан шаардлага, 9 тооны 481.2 сая төгрөгийн зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх оны үлдэгдэл 1 тооны албан шаардлага, 9 тооны 481.2 сая төгрөгийн зөвлөмж бүрэн хэрэгжсэн.

ЗУРГАА. Дотоод ажлын талаар:

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

ТАБ-ын удирдах ажилтны семинараар МУЕА, МУЕА-ын орлогч, Тамгын газрын дарга, СУГ-ын захирал, ХШҮДАГ-ын захирал, ЧБГ-ыг захирал, Төрөлжсөн аудитын газрын захирлуудаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, цаашид анхаарах асуудлуудыг хэрэгжүүлж ажилласан.

ҮАГ-ын Тамгын газраас 10 дугаар сарын 28-ны өдрийн 03/3017 тоот албан бичгээр ирүүлсэн байгууллагын дотоод үйл ажиллагаа, хүний нөөц, ажлын байрны зохион байгуулалт, авилгын эсрэг үйл ажиллагаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр өгсөн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ҮАГ-аас цар тахал болох коронавируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 20 зөвлөмж чиглэлийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн дагуу ажилчдад амны хаалт, гар ариутгагч тараан, дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр ханган ажлын байрыг мэргэжлийн байгууллагаар 2 удаагийн давтамжаар бүрэн ариутгал хийлгэж, мөн ажилтан, албан хаагчдыг УОК-ын шийдвэр зөвлөмжийн хүрээнд илүү цагаар ажиллуулахгүй байх арга хэмжээ авч ажилласан.

ҮАГ-ын удирдлагаас 03 дугаар сарын 10-ны өдөр хийсэн цахим хурлаар МУЕА-ын орон нутаг хариуцсан орлогч, Тамгын газрын дарга нар шинэ короно вирус өвчлөлтэй холбоотойгоор ажлын цагийг богиносгон харилцагч талуудтай цахимаар харилцах, 0-12 настай хүүхэдтэй эцэг, эхэд цалинтай чөлөө олгох, гэрээсээ ажлаа хийх боломжоор хангах, өрөө, компьютер техник хэрэгслийг сайтар цэвэрлэж байх зэрэг чиглэл өгснийг бүрэн хэрэгжүүлсэн.

ҮАГ-аас ХАСХОМ, баталгааны маягт, бүртгэлийн дэвтэр, тайлан мэдээг холбогдох хугацаанд архивд шилжүүлэх, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах чиглэлийн дагуу хариуцсан нууцын ажилтан 2008-2013, 2014-2015 оны ХАСХОМ-ын 2 ш баримтыг байгууллагын архивд шилжүүлэн нууцлалыг ханган ажилласан.

Цахим хурлаар өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийг ажилтнуудад танилцуулан хэрэгжүүлж ажилласнаар хөдөлмөрийн дотоод журам зөрчигдсөн болон аливаа ёсзүйн зөрчил гараагүй, Төрийн аудитын газар, аудиторруудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг МУЕА-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/20 тоот тушаалаар баталсан журмын дагуу хийж баталгаажуулсан.

ҮАГ-аас "Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар"-ыг баримталж ажиллах чиглэлийн дагуу нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулах, дүгнэлт гаргах аудитыг хийсэн.

СТА-ын тайланг шинэ загварын дагуу баталгаажуулах ажлын хүрээнд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дуусгавар болсон тайланг шинэ загварын дагуу бэлтгэж ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2019 онд "Аудитын баримтжуулах бодлого, аргазүйг боловсронгуй болгож, төлөвлүүлэх" зорилтын биелэлтийг 7 асуудлаар гаргаж МУЕА-ын орлогчид 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 тоот албан бичгээр хүргүүлсэн.

МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, 2019 оны А/60 тоот тушаал, УАГ-ын 2019 оны А/87 тоот ерөнхий чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай албан бичиг, САГ-аас ирүүлсэн төсвийн шууд захирагчдын аудитын тайлангийн загвар, анхаарах зүйлс зэргийг баримтлан санхүүгийн удирдлагын системийн СТАУС-2 программад оруулан санхүүгийн тайлан баталгаажуулах аудитыг хийлээ.

Мөн санхүүгийн тайлангийн аудит, СТАУС программын чиглэлээр өгсөн МУЕА-ын А/76 дугаар тушаал, 2986 тоот албан бичиг, СУГ-ын 04/2828 тоот албан бичгүүдийг хүлээн авч өгсөн үүрэг, чиглэлийг ажилдаа мөрдөн ажиллаж байна.

МУЕА баталсан ерөнхий чиглэлийн дагуу аудитад хамрагдсан 222 байгууллагын төлөвлөлт, болон гүйцэтгэлийн үе шатанд 8-28 чиглэлээр эрсдэл сонгон гүйцэтгэж, хавсралт судалгааг аудит хамрагдсан 218 байгууллагаас авч нэгтгэж, улсын төсвийн байгууллагын авто тээврийн хэрэгслийн судалгааг УАГ-т хүргүүлэн, орон нутгийн төсвийн байгууллагын судалгааг нэгтгээд байна. Санхүүгийн аудитын бодлого, арга зүйг төлөвшүүлэх, боловсронгуй болгох зорилтын хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 5-р сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Албан даалгаврын хүрээнд санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлууд хийгдлээ. Үүнд аудитад хамрагдах байгууллагын талаарх мэдээллийн санд дахь 224 байгууллагын мэдээллийг шинэчилж, санхүүгийн тайланд хамрагдах байгууллагын ерөнхий мэдээлэл, байгууллагын 16 оронтой кодыг зааварчилгааны дагуу оруулж нягталсан, дүн шинжилгээ хийх, шинэчлэх ажилд нийт 226 байгууллагын мэдээлэл дээр ажиллаж сүүлийн 3-н жилд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байдал, алдаа зөрчил, авсан дүгнэлт зэргийг үндэслэн Монгол Улсын ерөнхий аудитораар батлуулах 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагын жагсаалтыг санхүүгийн тайланд аудит хийх журмын 10.5-д заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгаж А20101 маягтаар, журмын 10.7-д заасан нөхцөл шаардлагыг үндэслэн аудит хийх хэлбэрийг А30101 маягтаар баталгаажуулж 10.8-д заасны дагуу байгууллагын 83 тоот албан бичгээр УАГ-ын Стратеги удирдлагын газар хүргүүлсэн.

Мөн дараагийн шатны ажил болох санхүүгийн тайлангийн аудитын хуваарь гарган батлуулж Төрийн аудитын байгууллага 221, ХАК-д 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгэхээр төлөвлөн, 8 аудитор, 2 гэрээт ажилтан авч ажиллан 2020 оны санхүүгийн тайланд 224 байгууллага хамруулахаас 118 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах, 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит гэрээгээр хийлгэх, 103 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийхээр төлөвлөн баталгаажуулж СТАУС программад оруулан хуваарийг хийж төлөвлөлтийн өмнөх ажил эхлээд байна.

Дотоод сургалт: Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий болон дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй уялдуулан дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа.

УАГ-аас 04 дүгээр сарын 02-ны өдөр ахлах аудиторуудыг Удирдлагын академийн сургалтанд хамруулах цахимаар ирсэн бичгийн дагуу бүртгүүлэн ажлын байран дээрээс цахимаар суралцуулж 05 дугаар сарын 07-ны өдөр шалгалтыг амжилттай өгч тэнцсэн, өгсөн даалгаврыг 05 дугаар сарын 12-ны өдөр хийж цахимаар өгөөд байна.

ҮАГ-аас цахимаар Хуулийн хэрэглээ (Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга) сэдэвт сургалт, шалгалтыг зохион байгуулсан танхимын сургалтаас илүү маш үр дүнтэй сургалт болж аудиторуд идэвхтэй оролцсон, хуулийн хэрэглээний талаар өргөн мэдлэг авсан, цахим сургалтын шалгалтыг өгөхийн өмнө аудиторуд мэдлэг, туршлагаа солилцож, хуваалцан бататгаж харилцан ярилцсан нь сургалтын ач холбогдол оршиж байлаа.

Цаашид шинээр боловсруулсан, батлагдсан хууль, журам, заавар, стандартын сургалтыг ийм хэлбэрээр зохион байгуулах нь чухал байна.

Аудиторуд мэргэшсэн нягтлан бодогчийн 2 удаагийн сургалт, шалгалтанд хамрагдаж 3-5 шалгалт өгснөөс 2 аудитор дөрөв, дөрөв, 2 аудитор нэг, нэг хөнгөлөлт авлаа.

ТАБ-ын удирдах ажилтны семинараар МУЕА, МУЕА-ын орлогч, Тамгын газрын дарга, СУГ-ын захирал, менежерүүд, ХШҮДАГ-ын захирал, ЧБГ-ыг захирал, Төрөлжсөн аудитын газрын захирлууд, “Дижитал 2025” төслийн менежер нарын илтгэлийг танилцуулсан.

Нийгмийн асуудал:

Монголын цагаан сар, Олон улсын ахмадыг өдрийг тохиолдуулан газрын харьяат 3 өндөр настанд 300.0 мянган төгрөгийн хүндэтгэл удитор А.Сувдаагийн өвөө аав нас барсан тул 500.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж тус тус үзүүлсэн, шинээр гэр бүл болсон, шинэ хүүхэдтэй болсон нэг ажилтанд дотоод журмын дагуу 800.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон ажилтнуудад улирлын ажлын үр дүнгээр 24.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Архив, албан хэрэг хөтлөлт: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хууль эрх зүйн актуудад нийцүүлэн хөтөлж байна. Дарга, тэргүүлэх аудиторын А тушаал 32, Б тушаал 15 гарч, явуулсан бичиг 452, ирсэн бичиг 173 тус тус бүртгэгдэж хугацаатай бичгийг хугацаанд хянан шийдвэрлэн хүргүүлсэн.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт нийцүүлэн баримт бичгийг боловсруулах, ирсэн бичгийг хүлээн авах бүртгэх, удирдлагаар цохолт хийлгэх, хариу бичгийг боловсруулан, баримт бичгийн шийдвэрт хяналт тавин ажиллаж байна.

2020 онд хийсэн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын баримт, материалыг аудиторуд баримтуудаа архивын нэгж болгон үдсэн, Архивын хууль, тогтоомжийн дагуу 7 дугаар сард хариуцсан ажилтнууд комиссоор хянуулан хүлээлгэн өгч, архивласан.

Байгууллагын 2019 оны хөтлөгдөж дууссан гүйцэтгэлийн аудитын 10 баримт, нийцлийн аудитын 7 баримт, санхүүгийн аудитын 45 баримт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 6 баримт нийт 68 хадгаламжийн нэгжийг архивын хууль, тогтоомж, стандартын дагуу үдэж, хавтаслан архивт хүлээж авсан.

2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт-ыг албан хаагч тус бүрээр гаргуулж, нэгтгэн баталгаажуулсан байна. Байгууллагын архивын баримтын хадгалалтын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангах, эмх, цэгц, хадгалалтыг сайжруулан ажиллаж байна.

Судалгаа, мэдээ, тайлан: Дараах журам, заавар, аргачлалын төслийг багаар хэлэлцэн, саналыг холбогдох хугацаанд нь ҮАГ-т хүргүүлэв. Үүнд:

1.“Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”,

2. "Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам",

3. "Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар",

4. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтооход ашиглагдах аргачлал",

5. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал",

6. "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх"

7. "Санхүүгийн аудитын чиглэлээр хамтран ажиллах" зэрэг ҮАГ-аас ирсэн заавар аргачлалын төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх үндсэн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох "Дижитал аудит 2025" судалгаанд бүх албан хаагчид хамрагдсан байна.

Тамгын газрын даргын баталсан "Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудыг арга зүйгээр ханган ажиллах ажлын төлөвлөгөө"-г мөрдөж ажиллалаа.

Ажилтнуудын нийгмийн аж байдлын судалгааг гаргаж 03 дугаар сарын 06-ны өдөр Хүний нөөцийн албанд цахимаар хүргүүлсэн.

ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтыг 01 дүгээр сарын 07-ны өдөр Тамгын газрын хүний нөөцийн албанд цахимаар хүрүүлж, аудиторуудын ХАСХОМ-ыг 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргуулж хянаж баталгаажуулсан.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар төлөвлөгөө боловсруулан дотоод сургалтын төлөвлөгөөнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хуулиудыг сургалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн аудитын үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлөөс ангид гүйцэтгэн, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.

Тайлант хугацаанд 1 өргөдөл хүлээн авч хугацаанд нь шийдвэрлсэн.

Төрийн аудитын газрын үйл ажиллагаа, хийсэн аудитын дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэхдээ зөвшөөрлийн хуудсаар боловсруулсан, хянасан, мэдээлсэн албан тушаалтнаар баталгаажуулан баримтжуулж орон нутгийн хэвлэл, цахим сайтад байршуулж хэвшсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт өгсөн 114 байгууллагын дуусгавар болсон тайланг төсвийн захирагч нарт хүргүүлсэн, аудитын тайланг audit.mn сайтад байршуулсан, хэвлэмэл болон бусад байгууллагад хувилж өгсөн 131 тайлан, газрын албан ёсны пэж хуудас нээж олон нийтэд мэдээлэл хүргэж байна.

МУЕА-ын 2018 оны А/236 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохицуулах журмыг мөрдөн компьютерын нууц үгийг шаардлагад нийцсэн байдлаар оруулахыг зөвлөж, цахим шуудан, хортой код зэргийг албан хаагч бүрд суулган ажиллаж, техник хэрэгсэлд ямар нэг эвдрэл, гэмтэл гаргаагүй хэвийн ажиллалаа.

Хамтын ажиллагаа:

Аймгийн Прокурорын газартай төрийн албанд ажлын хариуцлага сахилга батыг сахин бэхжүүлэх, хууль зөрчсөн аливаа үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоох, төрийн аудитын байгууллагаас тавигдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд нь хангуулж, буруутай этгээдэд хуулийн хүрээнд хариуцлага тооцуулж, байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэний буруутай үйлдэл үйл ажиллагаанаас төрд хохирол учрах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой “Санамж бичиг”-ийг 04 дүгээр сарын 13-ны өдөр байгуулж баталгаажуулсан.

Санамж бичгийн хүрээнд Төрийн аудитын газраас аудитын явцад илрүүлсэн шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагатай төлбөрийн актын судалгаа, мэдээллийг гаргаж аймгийн Прокурорын газарт 10 дугаар сарын 09-ний өдрийн 420 тоот албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллаж байна.

ҮАГ-ын САГ-аас ирүүлсэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 06/1476, 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/662 тоот тэтгэвэр тогтоолгосон иргэн төрийн албанд ажиллахад хэрхэх талаар ирүүлсэн тодруулга, зөвлөмжийн хүрээнд аймгийн Санхүү дотоодын аудитын албатай хамтран энэ чиглэлээр гарч байгаа сүүлийн үед хавтгайрах шинжтэй болсон зөрчлийг таслан зогсоохоор ажиллаж байна.

АТГ-тай хамтарч судалгаа, дүн шинжилгээ хийх зорилгоор аймаг дахь Төрийн аудитын газраас бичсэн акт, өгсөн албан шаардлага 2018 оны 94 албан шаардлага, 26 төлбөрийн акт 2019 оны 25 албан шаардлага, 45 төлбөрийн актыг PDF файл болгон бэлтгэж ҮАГ-т хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 45 дугаар тогтоолоор МУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах чиглэлээр аймгийн ЗДТГ-ын Хуульзүйн хэлтэст “Хяналт шалгалтаар илрүүлсэн, МУ-ын Үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлт үйл явдлын тухай” мэдээллийг хүргүүлж санал солилцож ажиллалаа.

Аудитын ил тод байдал, аудитад олон нийтийн оролцоог хангах зорилгоор Булган сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2017-2020 оны үйл ажиллагааны үр дүнгээр нийтийн сонсгол хийх ажлын хүрээнд аймгийн “Лебирал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ байгууллагатай хамтран ажиллаж холбогдох мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн.

Аймгийн ЭМГ-тай хамтарч ажиллахаар ирүүлсэн гэрээний төсөлтэй танилцаж ажилтнуудыг эрүүл мэндийг үзлэгт хамруулахад хамтран ажилласан.

Орон нутгийн сонгуулийн үр дүнгээр аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга шинээр томилогдсон тул ИТХ, Засаг даргаас Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, ажиллах нөхцлийг сайжруулах, орон тоо нэмэгдвэл шинээр өрөө

гаргаж өгөх чиглэлээр дэмжлэг үзүүлэх, харилцан хамтран ажиллах талаар санал солилцон ажиллаж байна.

ДОЛОО. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл:

Тайлант хугацаанд газрын төсвийг 426.7 сая төгрөг батлагдсанаас ХБГ-ээр бүрэн зарцуулагдана.

Газрын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг тухай бүр хугацаанд нь Ажлын албанд хүргүүлсэн, шилэн дансны тухай бүр мэдээлэх 8, сар бүр мэдээлэх 3, улирал бүр мэдээлэх 1 мэдээг хугацаанд мэдээлсэн, хугацаа хоцроосон мэдээ байхгүй байна.

Аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны санхүүгийн тайланг УБ хотын "Грант тронтон аудит" ХХК-д баталгаажуулах аудит хийлгэн зөрчилгүй санал дүгнэлт авсан, асуудлын бүртгэлээр ТАБ-ын хэмжээнд НБББББ-г шинэчлэх зөвлөмж өгсөн байна.

МУЕА-ын орлогч С.Бүрэнбатад 30.0 сая төгрөгийн дансны үнэтэй, цаашид албан хэрэгцээнд ашиглах боломжгүй болсон хуучин автомашиныг акталж данснаас хасуулах саналыг 04 дүгээр сарын 08-ны өдрийн 156, YAГ-ын Тамгын газрын дарга Ц.Ганболдод аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны төсөвт тусгах 55.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг 04 дүгээр сарын 14-ний өдрийн 162 тоот албан бичгээр тус тус хүргүүлж ТӨБЗГ-ын 518 тоот тогтоолоор дуудлага худалдаанд оруулах шийдвэр гарсан.

Байгууллагын батлагдсан төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүрийн 2-ны дотор гарган YAГ-ын ерөнхий санхүүчид, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлсэн, YAГ-т 2 нэр төрлийн 1.2 сая төгрөгийн хөрөнгө акталсан тайланг 04 дүгээр сарын 01-ний өдрийн 148 тоот албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны мэдээллийн самбараар байгууллагын чиг үүрэг, тухайн жилийн батлагдсан төсөв болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, холбогдох хууль эрх зүй, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээлэл, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, шилэн дансны цаг үеийн мэдээлэл, бусад мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол мэдээлж, shilendans.gov.mn, цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 онд 78 мэдээллийг бүрэн мэдээлж байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан.

НАЙМ. Дүгнэлт, санал:

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинээр гарч байгаа стратеги, бодлого, стандарт, дүрэм, журам, заавар, аргачлалыг тухай бүр сайтар судлан танилцаж хэрэгжилтийг ханган аудитын чанар, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Төрийн албаны хууль, журмын шинэчлэлтэй холбогдуулан аймаг дахь Төрийн аудитын газрын болон аудиторуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинээр боловсруулан мөрдөж бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Шинэ төрлийн ковид-19 өвчлөлтэй холбоотой улс, аймгийн Онцгой комисс, YAГ, аймаг, сумын ЗДТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Тайланд онд аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, актын биелэлт харьцангуй биелж гарсан, "Covid-19" өвчлөлтэй холбоотой хөл хорионы дэглэм удаан хугацаанд үйлчилсэн ч ажил хэвийн явагдсан, зарим албан шаардлагын биелэлт, зөвлөмжийг тооцоход дутуу хэрэгжсэн, сонгуулийн жилтэй холбогдуулан хариуцлага тооцох албан тушаалтнууд ажлаасаа чөлөөлөгдсөн, аудитын

газраас шалтгаалахгүйгээр Захиргааны хуулийн 103-р зүйлийн хэрэгжилт удаашралтай байна.

Хийсэн аудитын дүнгээс:

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, шилэн дансны аудит жил бүр хийгдэж байгаа тул ахиц өөрчлөлт гарч байгаа ч хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан хугацаанд ажил дуусдаггүй он дамждаг, ажил нь дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгодог, зориулалт бус санхүүжилт олгодог, хугацаа хэтэрсэн хоногт гэрээний дагуу алданги тооцоогүй зэрэг ажлын чанар, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналттай холбоотой,
- ✓ сум бүрт байдаг сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг сангуудын үйл ажиллагааг сайжруулах, үр дүнг тооцдог байх зэрэг зөрчилд анхаарч үр нөлөөг сайжруулах,
- ✓ тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн хүнийг ажилд нь эргээж томилдог, нэмэгдэл цалинг хуучин хэвээр нь мөрдөж олгодог, хөдөлмөрийн чадвараа 70-80 хувь алдаж групп тогтоолгосон хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах тухай хуулиар хэвийн ажлын горимоор ажил, үүргээ бүрэн гүйцэтгэж цалин, тэтгэмж давхар аваад явж байгаа зэргийг судалж нэг мөр шийдвэрлэх шаардлага байна.

Цаашид Төрийн аудитын байгууллагын хэмжээнд гүйцэтгэл, нийцлийн аудитын үр дүнг цахимжуулах, ажлын гүйцэтгэл, тайлагналд орчин үеийн шинэ техник, технологи, судалгаа, шинжилгээний материал ашигладаг байх, ажилтнуудын хууль эрхзүйн мэдлэг, аудитын процессын ажлыг нягт хийлгэж хэвшүүлэх, аймаг хооронд ажлын бүтээлч туршлага солилцдог байх зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулж байх саналтай байна.

Санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын ажлын ачаалал, аудитын чанар, үр өгөөжид хүн хүчний нөөц, хууль эрхзүй, барилга, зураг төсвийн чиглэлийн мэргэжил ур, чадвар бүхий боловсон хүчин шаардлагатай байгаа тул орон тоог нэмэгдүүлэх саналтай байна.

ЕС. Хавсралтууд:

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ